

# ***GOBI***

MONGOLIAN CASHMERE

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “НООС НООЛУУРАН  
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

Говь ХК-ийн тэргүүн дэд захирал Ц.Оргилболд

**Боловсруулсан:**

Тогтвортой хөгжлийн хэлтэсийн дарга Э.Ивгээл

Байгаль орчны менежер Д.Нандингэрэл

**Улаанбаатар хот 2023**

## АГУУЛГА

### ОРШИЛ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ
  - 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
  - 3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
  - 3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
  - 3.4.
  - 3.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
  - 3.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
  - 3.7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
  - 3.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
  - 3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
  - 3.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

## ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2018 онд нэмэлт тодотгол хийгдсэн Ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А-618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр “Ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр” төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар байнга авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоож өгсөн болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн 2023 оны үйл ажиллагааны хүрээнд хамаарах хэсгүүдийг уялдуулан хийгдсэн бөгөөд цаашид нэмж төлөвлөх, авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа тодорхойлон гаргаж ирснээр ирэх жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх боломжтой юм.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А-618 тоот тушаалын хавсралт “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ”-ын дагуу гаргаж, төсөл хэрэгжүүлэгч нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлнэ.


## 1. ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 1.1. Товч танилцуулга

<b>Төслийн нэр:</b>	Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр
<b>Төсөл</b>	“Говь” ХК
<b>хэрэгжүүлэгчийн</b>	Улсын бүртгэлийн дугаар: 9010001061
<b>нэр:</b>	Регистрийн дугаар: 2076357
<b>Хаяг:</b>	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, үйлдвэрийн гудамж, өөрийн байр
	Утас:+976-70105511

**Төслийн байршил:** Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд тус дүүргийн Засаг даргын 2017 оны 02 сарын 03-ны өдрийн А/55 тоот шийдвэрээр олгогдсон 178013/001 18639309696233 тоот нэгж талбарын дугаар бүхий үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмших 49883 м<sup>2</sup>, 178013/0060 18639309770292 тоот нэгж талбарын дугаар бүхий конторын зориулалтаар эзэмших 4467 м<sup>2</sup> талбайд байрлана.

№	Өргөрөг			Уртгаг		
1	47	54	12.6	106	52	15.3
2	47	54	10.1	106	52	12.7
3	47	54	9.4	106	52	13.1
4	47	54	4.9	106	52	2.6
5	47	54	8.6	106	52	0.7
6	47	54	9.2	106	52	1.5
7	47	54	14.9	106	51	57.9
8	47	54	18.4	106	52	10.3



Зураг.1 Төслийн талбайн байрлал /google earth/

## 1.2. Төслийн хүчин чадал

Монголын ноос, ноолуурын салбарын анхдагч “Говь” үйлдвэр нь 1981 онд Япон улсын хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан бөгөөд экологийн цэвэр бүтээгдэхүүн болох Монгол ямааны нарийн микронтой 100%-н цэвэр ноолуураар хамгийн дэвшилтэт техник технологийг ашиглан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг дэлхийн топ 5 үйлдвэрлэгчийн нэг юм. Өнөөдрийн байдлаар Монгол улсын ноос ноолуурын салбарт дотоодын нийт зах зээлийн 50-с дээш хувийг дангаар эзэлж, дэлхийн хувцас загварын хөгжилтэй зэрэгцсэн хэмжээнд хөгжсөн амжилтаар өнөөг хүртэл 41 жил тасралтгүй үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа үндэсний томоохон үйлдвэрлэгчдийн нэг юм. "Байгаль орчинд халгүй технологи" хэрэглэх бодлогыг баримтлан үйлдвэрийн техник, технологийн горимоо шинэчлэн ажиллаж байна.



*Зураг.2 Говь ХК-ийн үйлдвэрийн байр*

Говь ХК нь Анхан шатны үйлдвэр, Ээрмэлийн үйлдвэр, Сүлжмэлийн үйлдвэр, Нэхмэлийн үйлдвэр, Оёмолын үйлдвэр гэсэн нийт 5 үйлдвэрийн 2600 гаруй ажилтантай 5 газар, 12 хэлтэс, 29 албатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Жилдээ дунджаар 900 тонн түүхий ноолуур боловсруулах 500 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 150,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэж гадаадын зах зээлд дэлхийн 30 гаруй орны 140-өөд харилцагчиддаа "Монголд үйлдвэрлэв" гэсэн шошготойгоор 100% ноолууран бүтээгдэхүүн нийлүүлж байгаа бөгөөд дотоодын зах зээлийн 70 гаруй хувийг дангаар эзэлдэг. Нийт 9 нэрийн барааны дэлгүүр, 7 гэрээт борлуулагчаараа дамжуулан дотоодын худалдан авагчдадаа бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэдэг. Мөн “Говь” ХК нь орчин үеийн хувцас загварын чиг хандлагатай хөл нийлүүлэн алхаж, дэлхийн

хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Италийн болон Европын хувцас загварын нэр хүнд бүхий дизайнеруудтай хамтран ажиллаж олон улсын хувцас загварын компаниудын жишгээр жилдээ хавар, зуны болон намар, өвлийн гэсэн загварын коллекцийг гаргаж байна.

### 1.3 Технологийн үйл ажиллагааны үндсэн зарчим

Үйлдвэрлэлийн технологи нь ангилан ялгах, угаах, хялгас ялгах, самнах, будах, холих, ээрэх, шилжүүлэн ороох, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах лабораторийн хяналт савлах зэрэг шат дамжлагуудтай юм. Эдүгээ 30 гаруй жил тасралтгүй үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаагийн гол үндэс нь дэлхийн зэрэглэлийн хамгийн сүүлийн үеийн техник, технологийг тасралтгүй шинэчлэн, нэвтрүүлсэн юм.

#### Говь ХК-ийн техник, технологийн түүхэн замнал

Хүснэгт 1

Он	Техник, технологийн шинэчлэлийн түүх
1981	Япон улсын засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт буцалтгүй тусламж олгож, Улаанбаатар хотноо ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр байгуулах тухай хэлэцээр байгуулж Монгол-Японы хамтын ажиллагааны хүрээнд Говь үйлдвэр үүд хаалгаа нээлээ.
1987-1989	Компьютерийн автомат удирдлага бүхий Япон улсын SET-092 сүлжих машиныг үйлдвэрт суурилуулав.
1991	Олон улсын стандарт ISO-9000 тэмдэгтийг үе шаттайгаар нэвтрүүлж, олон улсын чанарын цом болон гэрчилгээг Монгол улсаас анх удаа авсан.
1994	Япон улсын Shima Seiki брэндийн компьютерийн удирдлагатай сүлжих машиныг суурилууллаа. ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, №1 гэрчилгээг гардан авлаа.
1995-1996	Монгол улсад анх удаа олон улсын чанарын ISO-9001:2000 тэмдэгтийг нэвтрүүллээ. Итали улсын технологи тоног төхөөрөмжөөр ээрмэл, нэхмэл, сүлжих үйлдвэрийн өргөтгөлийг хийж, 8.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийв.
1997	Монголд анх удаа ноос ноолууран өргөн хөнжил, ноолууран даавуу, драп, нарийн номерын ээрмэл утас үйлдвэрлэх “Говь-2” үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авав.
1999	Гадаад зах зээлээ өргөжүүлэн 30 гаруй оронтой түншийн харилцаа тогтоож, АНУ-ын зах зээлд анх удаа 45,000 ширхэг бүтээгдэхүүн нийлүүлэв.

2000	Утас будах технологи болон орчин үеийн компьютерийн системд холбогдсон сүлжих машинуудыг суурилуулав. Будах үйлдвэрийн техник, технологидоо олон улсын чанарын ISO-1004 тэмдэгтийг нэвтрүүлээ
2004	Герман улсын Stoll үйлдвэрийн компьютерийн удирдлага бүхий сүлжих машинаар өргөтгөл хийв.
2007	“Говь” үйлдвэрийн төрийн мэдлийн хувьцааг Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар “ЭФ СИ АЙ” ХХК худалдан авав.
2008	Говь үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн барилгын дизайныг Японы алдарт архитекторч Сайко Кейчиро шинээр хийж, дэлгүүр зургадугаар сард нээлтээ хийлээ. Япон улсын Shima Seiki брэндийн өндөр хүчин чадал бүхий компьютерийн бүрэн удирдлагатай сүлжих SSG122SV маркийн машин, ээрэхийн үйлдвэрт Итали улсын Stalam болон 66-DD 14G Conti Complett брэндийн машинуудыг суурилуулан үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөтгөв.
2009	Японы Токио хотод өөрийн салбар дэлгүүрээ нээлээ. Италийн “VVA Consulting Company”-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа. Говь Үйлдвэрт техник, технологийн шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийж, Итали, Япон, Швейцарийн тоног, төхөөрөмжүүд суурилууллаа.
2010	Монголын ноолуурын салбарт анх удаагаа Принт технологийг нэвтрүүлэн, ноолуур дээр зургийг барлан буулгадаг технологитой боллоо
2011	Тоног төхөөрөмжийн шинэтгэл, өргөтгөлд зориулж 7,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийв Монгол улсад 6 нэрийн барааны дэлгүүрийг шинээр нээв Үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлэн, шинээр 300-аад ажлын байрыг зарлалаа
2012	Монгол ямааны ноолуурын үндсэн дөрвөн өнгийг цайруулж, будахгүйгээр байгалийн өнгөөр нь бэлэн бүтээгдэхүүн болгох Gobi-Mongolian Organic Cashmere брэндийг худалдаанд гаргалаа. Gobi by Saverio Palatella 2012 оны Намар, Өвлийн 100% ноолууран шинэ коллекциог гаргав.
2013	Сүлжих болон болон хялгас ялгах, самнах технологийг шинэчлэн, үйлдвэрлэлийн хэмжээнд нийт 5,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.

	<p>Сүлжмэлийн машины шинэ технологи болох Whole Garment буюу оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүн сүлжих машинуудыг суурилуулав.</p> <p>Gobi-Mongolian Organic Cashmere болон Хямдралын дэлгүүрийг шинээр нээв.</p> <p>IFF-JFF БОЛОН Panorama, Фестиваль моды, Import Goods Fair зэрэг Япон, Герман, ОХУ, Солонгос, Хятад зэрэг улсуудад зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэнд амжилтай оролцсон.</p> <p>Европын сонгомол хээтэй Баракко загварын драпан оёмол бүтээгдэхүүнийг 5 төрлөөр үйлдвэрлэж, Шилдэг бүтээгдэхүүнээр шалгарав</p>
2014	<p>Бельгийн Брюссель болон Швейцарийн Женев хотод салбар дэлгүүрээ нээснээр, гадаад зах зээлд нийт 47 салбар дэлгүүртэй болов.</p> <p>Будах үйлдвэрийг бүрэн автоматжуулж, ээрмэл утасны агуулахыг 2 дахин өргөтгөж, 50тн-ийн багтаамжтай болгов.</p> <p>Нэхмэл болон принтэт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэв.</p> <p>Монголд анх удаа хамгийн нарийн утсаар ваксдаж нэхдэг технологийг нэвтрүүлэв</p> <p>Сочи -2014 өвлийн олимпод оролцох баг тамирчдыг ивээн тэтгэлээ</p>
2015	<p>Пальто, пиджакны үлгэр суулт, оёдлын болон материалын чанарыг цоо шинэ технологийн дэвшилд хүргэх зорилгоор Японы Larine компанитай хамтран хамтран ажиллаж байна.</p>
2016	<p>Тансаг зэрэглэлийн YAMA брэндийг зах зээлд нэвтрүүллээ.</p>
2017	<p>2017 оноос эхлэн Хятадын шинэ загварын самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршсан. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 4 дахин эрчим хүч хэмнэх, ажиллах хүчийг 40% хэмнэх, чанарын үл тохирлыг 50% бууруулах, хаг хогны агууламжийг багасгах зэрэг сайжруулалт бий болсон тул энэ онд нэмэлтээр 5 шугам суурилуулсан.</p>
2018	<p>6 сарын 15-нд Төв аймгийн Сэргэлэн сумын 14.7 га газар шинээр барихаар төлөвлөж буй Анхан шатны цогц үйлдвэрийн шав тавих ёслолыг амжилттай зохион байгуулав.</p> <p>Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг үйлдвэрлэлд шинээр нэвтрүүлсэн.</p> <p>Ингэснээр утасны даацыг сайжруулахаас гадна бүтээгдэхүүнд бөөсрөлт үүсгэхгүй байх зэрэг эерэг үр дүнтэй. Цаашид Muratec шилжүүлэн ороох машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэх машинаар ээрнэ.</p> <p>2018 онд ноолууран пиджакны борлуулалтаар дэлхийд тэргүүлэх зорилгын хүрээнд эмэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан ХБНГУ-ын Indupress тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн. Цаашид эрэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан</p>



	<p>Malkan тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн масс үйлдвэрлэлийг эхлүүлнэ.</p> <p>Японы SHIMA SEIKI MACH2XS оёдолгүй сүлжих 6 ширхэг машиныг шинээр ашиглалтад оруулсан. Энэхүү машин нь бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжиж гаргахаас гадна цамцны захыг өөрөөсөө сүлжиж гаргах онцлогтой юм.</p>
2019	<p>МУ-ын ноолуурын салбарын томоохон бренд үйлдвэрлэгч “Гоёо” ХХК-ийг Дэлхийд танигдсан Монгол брэнд уриан дор “Говь” ХК-тай нэгтгэн авч, салбарын хамгийн том нэгдлийг амжилттай гүйцэтгэлээ. 2019 онд пиджак, өмд үйлдвэрлэхэд зориулсан Malkan фирмийн төрөл бүрийн зориулалттай хэлбэржүүлэх пресс тоног төхөөрөмжийг суурилуулсанаар дэлхийн жишигт нийцсэн эрэгтэй эмэгтэй хослол үйлдвэрлэж байна.</p>
2021	<p>Ээрмэлийн үйлдвэрийн самнах машин тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Италийн Autefa solutions фирмийн октир самнах 4 шугам авч суурилуулж байна. Ашиглалтанд оруулсанаар сүлжмэл бүтээгдэхүүний ноолууран утасыг чанарын өндөр төвшинд үйлдвэрлэж филлинг багасгах ач холбогдолтой.</p>
2022	<p>Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн баталгаажуулалтад Олон улсын стандартын SGS байгууллагаар аудитлагдан амжилттай гэрчилгээ гардан авлаа.</p>

## АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭР

### Ангилан ялгах алба

1981 онд анхан шатны үйлдвэрийн харьяа “Тар ялгах” цех нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлснээс хойш үйлдвэрлэлийн гол түүхий эд болох ямааны ноолуур, тэмээний ноосыг нарийн бүдүүн микрон /1мкм=0,001мм тэнцэнэ/ болон ноолууран дахь хялгас бусад хольц нэр төрлөөр нь мэдрэхүйн гар аргаар технологийн дагуу ангилан ялгалтыг хийдэг. Ямааны ноолуурыг байгалийн үндсэн 4 өнгөөр ялгадаг. Үүнд: 1-р өнгө буюу цагаан ямааны ноолуур, 2-р өнгө буюу улаан ямааны ноолуур, 3-р өнгө буюу хөх ямааны ноолуур энэ өнгө дэлхийн аль ч улсад байдаггүй зөвхөн “Говь” ХК-д ангилан ялгадаг маш ховор тансаг түүхий эд юм. Мөн 4-р өнгө энэ нь хар ямааны ноолуур юм. Ноолуурыг байгалийн 4 өнгөөр ялгахгаас гадна байгалийн үндсэн 4 өнгөтэй байдгаараа бусад улсынхаас онцлог. Жилдээ 500-600 тн ноолуур, 100-150тн тэмээний ноос, 20-30 тн сарлагийн хөөвөр ангилан ялгах хүчин чадалтай.



Зураг.3 Ноос, ноолуур жинлэх болон ангилан, ялгах хэсэг

### Угаах алба

Япон улсын Futaba компанийн угаах машинаар угаадаг. Угаах машин нь сэгсрэх, сэмлэх угаах онгоц, туслах онгоц, шахах гол хатаах хэсгээс бүрддэг цагт 350-450 кг ноос ноолуур угаах хүчин чадалтай. Ангилан ялгагдсан бохир ноос, ноолуурыг Япон улсад үйлдвэрлэгдсэн байгалийн гаралтай моноген, нойген мөн Итали улсад үйлдвэрлэгдсэн теридол савангаар угааж нарийн тоос, шороо, хог, өтөг бууц тослог зунгаг зэргээс салгаж дараагийн дамжлагад технологийн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлдэг. Хаг, их хагтай нэр төрлийн угаасан ноолууран дээрээ хаг хогийг унагаах зорилгоор хаг унагаагч бодис цацдаг.



Зураг.4 Угаах машин

### Хялгас ялгах алба

Япон улсын TORIGOE пүүсийн хялгас ялгах 5 ком машинаар угаасан ноос ноолуурын байгалийн хогт хольц, хялгасыг ялгаж самнасан ноолуур, ноос гаргах зорилготой. 2015 онд хятад улсад үйлдвэрлэгдсэн самнах машины толгой суурилуулсанаар бүтээгдэхүүний чанар илүү сайжирсан. Жилд 578 тн самнасан ноолуур, ноос гаргах хүчин чадалтай үйлдвэрлэлийн технологи нь маш нарийн орчны чийг температурыг тодорхой төвшинд барьж холиог зөв оновчтой тохируулах, машин тоног төхөөрөмжийн тохиргоо, машин баригчийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж стандартад нийцсэн байгалийн ширхэгтийг гэмтээхгүйгээр 100%-н самнасан ноос ноолуур үйлдвэрлэн гаргадаг онцлогтой.

2017 оноос эхлэн Хятадын DONGJIA үйлдвэрийн LFN186A самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршсан. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 4 дахин эрчим хүч хэмнэх, ажиллах хүчийг 40% хэмнэх, том үс, хаг хогны хэмжээг 50% бууруулах, хаг хогны агууламжийг багасгах зэрэг сайжруулалт бий болсон тул энэ онд нэмэлтээр 11 шугам суурилуулсан.



Зураг.5 Самнах, хялгас ялгах машин

### Баглах нэгж

Япон улсад үйлдвэрлэгдсэн HAN-EI маркийн баглах машинаар баглаа хийдэг. 1цагт 250 кг ноолуур баглах хүчин чадалтай. Хялгас ялгах 1,2-р албанаас ирсэн 80%-ийн ноолуурыг нэг төрөл, бэлтгэн нийлүүлэгч болон тухайн түүхий эдийг угаасан савангийн нэр төрлөөр нь зориулалтын бор таар, бор цаас, туузан төмөр, түгжээ төмөр, төмөр утас ашиглан баглааг 70 кг жингээс хэтрүүлэхгүй баглана. Хялгас ялгах 1,2-р албаны хялгас, богино ноолуур, холио, тунелийн хог болон бусд албанаас ирсэн хаягдлуудыг багладаг.



Зураг.6 Баглах машин

## ЭЭРМЭЛИЙН ҮЙЛДВЭР

### Будах алба

Самнасан ноолуурыг будах, цайруулах, цайруулж будах, бобинтой болон гогцоо утас будах, ороох, хатаах гэсэн технологи ажилбараар үйлдвэрлэлээ явуулдаг. Жилд 800-900тн задгай ноолуур будаж, цайруулах, цайруулж будах хүчин чадалтай. Итали улсын STALAM фирмийн радио долгионы хатаах машинаар, ширхэгтийг гэмтээхгүйгээр будсан ноолуур болон утсаа хатаадаг. Итали улсын Loris Bellini пүүсийн бүрэн автомат компьютерийн удирдлагатай будах чихэх, сэгсрэх, сугалах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон будахын машинтай. Өнгөний болон шинжилгээний өвч тоноглогдсон 2 лабораторитой. Гадаад, дотоодын хэрэглэгч захиалагчдын хүссэн өнгийг гаргаж, эрэлт хэрэгцээг нь хангаж ажилладаг. Одоо 1400 гаруй өнгөтэй. АНУ-ын Datacolor-800 аппаратаар эх загвартай нь өнгөний зөрүүг уншуулж баталгаажуулдаг.

Лабораторит чанарын 9 үзүүлэлтээр шинжилгээ дүгнэлт гаргаж ажилладаг ба лабораториор үйлдвэрээ удирдан ажиллаж байна. Үйлдвэрийн дамжлагад Англи, Швейцарь улсаас 90 гаруй төрлийн химийн бодис нийлүүлэгдэн ашиглагдаж байгаль орчин болон хүний биед нөлөөлөлгүй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг.



Зураг.7 Будах алба

### Ээрэх алба

Сүлжих, оёх нэхэх дамжлагуудыг ээрмэл утсаар хангадаг. Жилдээ 850-950тн сайн чанарын 100 хувийн ноолууран нэхмэлийн зориулалттай 14,5/1 16/1 номер, сүлжмэлийн 26/2, 24/1 номерын утас үйлдвэрлэх хүчин чадалтай. Холих, самнах, ээрэх, шилжүүлэн ороох, давхарлан ороох, эрчлэх гэсэн 6 үндсэн дамжлагатай. Ээрмэлийн 1,2-р үйлдвэртэй бөгөөд тоног төхөөрөмж нь сүүлийн үеийн компьютерийн удирдлагатай Итали, Японы мөлхөө ээрэх, шилжүүлэн ороох, давхарлах, эрчлэх машинуудтай. Цувимал болон утасны чанарыг туушийн хэлбэлзэл, номер, даац, суналт, эрч, чийг, пиллинг зэрэг үзүүлэлтүүдээр шалгадаг утасны 2 лаборатори, пиллингийн 1 лабораторитай. Ээрмэл утасныхаа үзүүлэлтүүдийг дээшлүүлэх дэвшилтэд мөлхөө ээрэх технологийг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөлхөө ээрэх нь цахилгааны хэмнэлттэй байгальд ээлтэй тоног төхөөрөмж юм. Олон төрлийн холио хийх хүчин чадалтай 3 холих машинтай. Мөн шинээр Италийн Autefa, Overhaul самнах машин суурьлуулан угсарч хүчин чадлаа нэмэгдүүлсэн.



Зураг.8 Ээрэх алба

## Нарийн ээрэх алба

Нэхмэлийн зориулалттай даавууны утас үйлдвэрлэдэг. Жилдээ 29тн 60/2, 48/2 номерын утас үйлдвэрлэх хүчин чадалтай. Холих, самнах, зүүт, нарийн зүүт самнах, сунгах, ээрэх, шилжүүлэн ороох, давхарлан ороох, эрчлэх гэсэн 18 дамжлагатай Итали, Япон улсын машин тоног төхөөрөмжтэй. Цувимал болон утасны чанарыг туушийн хэлбэлзэл, номер, даац, суналт, эрч зэрэг үзүүлэлтүүдээр шалгадаг утасны лабораторитай. Монгол улсад анх удаа Nm 48-60 номерийн 100% ноолууран нарийн ээрмэл утас үйлдвэрлэх технологийг суурьшуулж үйлдвэрлэл явуулж байна.

## СҮЛЖМЭЛИЙН ҮЙЛДВЭР



Зураг.9 Сүлжих алба

Компьютер удирдлагатай бүрэн автомат сүлжих машинаар загвар дизайны өргөн сонголт бүхий сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах сүлжих, оёх, боловсруулах, гүйцэтгэх гэсэн үндсэн 4 дамжлагатай сүлжмэлийн 3 үйлдвэр ажиллаж жилд 1,500,000 мянган ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж европын холбооны улсууд болон Япон, Америк, Канад, зэрэг орнуудад 30 гаруй хувийг экспортолдог. Сүлжмэлийн үйлдвэр нь 1000 гаруй ажилтантай.



Зураг.10 Оёх алба

## НЭХМЭЛИЙН ҮЙЛДВЭР

### Принтийн алба

Япон улсын Shima Seiki компанийн хамгийн сүүлийн үеийн технологиор хийгдсэн машин суурилуулж, ноолууран бүтээгдэхүүн дээр дүрс буулгах аргыг Монголд анх удаа нэвтрүүлсэн. Уг машин нь найман өнгийн тусгай будгаар өнгөний хязгааргүй сонголт бүхий бүх төрлийн зургийг ноолууран бүтээгдэхүүн дээр буулгаж хээ тавих үндсэн ажиллагаатай дамжлага юм. Хэрэглэгчийн хүссэн зураг хээг буулгаж танд зориулсан бүтээгдэхүүн гаргах онцлогтой.



Зураг.11 Принтийн алба

### Нэхэх алба

Япон, Итали, Герман, Хятад, Финланд, Швед улсад үйлдвэрлэгдсэн угаах, сэгсрэх, жигнэх, хатаах, үслэх, хяргах, сойздох, цацаг эрчлэх, агшаах, өргөн үслэх, болон боргоцой үслэх пресс индүү, оёдол, гар нэхэх, шалгах зэрэг 23 төрлийн машин тоног төхөөрөмжөөр жилд 63000-103000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай. Дэлхийн 30 гаруй орнуудад бүтээгдэхүүнийхээ 70 гаруй хувийг экспортолдог.



Зураг.12 Нэхмэлийн алба

## ОЁМОЛЫН ҮЙЛДВЭР

Анх 1996 онд зөөлөн оёдлын цех нэртэйгээр 7 ажилчинтай ноолууран даавуу драпаар жижиг цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлж байсан бол одоо даавуу драпаар төрөл бүрийн оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэн Монголдоо анх удаа дамжлагын системийг нэвтрүүлэн нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх цаг хугацааг хэмнэж, ажлын бүтээмж нэмэгдэн пальто, пиджак, дээл хүрэм, хантааз, өмд, юбка, тэмээний ноосон хөнжил, майк зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн 175 ажилтантайгаар үйл ажилагаагаа явуулж сард 2000 ширхэг, жилд 24000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай ажиллаж байна. Мөн оёмолын цех нь хоёрдогч түүхий эд болох ноолууран болон тэмээний ноосны дахин задалсан үзүүрээр хөнжил, аяны хөнжил, гудас зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн сард 300 ширхэг, жилд 3600-4000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. 2018 оноос пиджак үйлдвэрлэлийн дамжлагын шугамыг орчин үеийн дэвшилтэт технологиор шинэчилж, Турк улсын “Малкан”, Герман улсын “Индүпресс” компаниудын эрэгтэй, эмэгтэй пиджакны хэлбэржүүлэгч пресс индүүг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн юм. Ингэснээр дэлхийн стандартад нийцсэн төгс чанарын хослол болон пиджакийг урлаж байна.



Зураг.13 Оёмолын үйлдвэр



### Хими цэвэрлэгээ нөхөн засварын алба

“Говь” ХК-ийн Хими цэвэрлэгээ нөхөн засварын алба нь анх 1999 онд Хими цэвэрлэгээ нөхөн засах цех нэртэйгээр 4 хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулагдаж байсан ба зөвхөн нөхөн засвар, нойтон угаалга шаариглалтыг гадна талаас нь түүж цэвэрлэдэг байсан.

Одоо цар хүрээгээ тэлэн 4 хүлээн авах цэгээр бүтээгдэхүүнийг хүлээн авч 19 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Хими цэвэрлэгээ нөхөн засварын алба нь бүх төрлийн сүлжмэл болон нэхмэл бүтээгдэхүүнд хуурай болон нойтон цэвэрлэгээ хийж шаариглалтыг түүж цэвэрлэнэ.



Зураг.14 Хими цэвэрлэгээ нөхөн засварын алба

### ЧАНАР СТАНДАРТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Чанар стандарт баталгаажуулалтын хэлтэс нь дотоод хяналтын албаны дарга нар, лаборант, бэлэн бүтээгдэхүүний шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр бүх төрлийн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнд чанарын давхар хяналт хийж чанарыг стандарт, норматив техникийн баримт бичигт заасан хэмжээнд хүргэх, лабораторийн шинжилгээний үнэний магадлалд хяналт тавин ажилладаг. “Говь” ХК нь 1995 онд Монгол улсын хэмжээнд анх удаа олон улсын ISO-9001 чанарын стандартыг нэвтрүүлсэн.

Хялгас ялгах, ээрэх, будахын лабораториудыг сорилт шинжилгээг гүйцэтгэхэд шаардлагатай Япон, Швейцарь улсын орчин үеийн компьютерт багажаар шинэчлэн тоногдсон нь ноос ноолуур судлалын зарим шинжилгээг шинэ шатанд гаргаж чаджээ.

Цаашид лабораториудын шинжилгээнд ашиглагдаж байгаа багаж төхөөрөмж хэмжих хэрэглэлүүдийн баталгаажуулалтыг тогтмолжуулж шинжилгээний аргачлалуудыг үндэсний болон олон улсын стандартчилалд хамруулахаар зориж ажиллаж байна.



Зураг.15 Чанар стандарт баталгаажуулалтын хэлтэс

### ТЕХНИКИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС


Техникийн удирдлагын хэлтэс нь 20 нарийн мэргэжлийн механик инженерүүдээр удирдуулсан 156 гаруй засварчид ажилладаг. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөл бололцоог ханган их засвар урсгал засварыг хийж гүйцэтгэдэг.



Зураг.16 Техник удирдлагын хэлтэс

### “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС”

Говь ХК нь үйлдвэрлэлийн хүчин чадал олон улсын жишигт нийцсэн чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Тогтвортой хөгжлийн хэлтэс нь 9 хүний бүрэлдэхүүнтэй Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны үндсэн 3 тулгуур үзүүлэлтүүдийг ханган байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэн ажилладаг. Тогтвортой хөгжлийн хэлтэс нь Тэргүүн дэд захирлын шууд удирдлагаар Байгаль орчны шууд болон шууд бус ашиглалтын нөөцийг зохистой хэрэглэх төлөвшүүлэх гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах ажлын хүрээнд бид 2019 оны 04-р сарын 07-ны өдрөөс эхлэн Байгаль орчны Удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартыг жил бүр хэрэгжүүлэн ажиллаж 2022 онд ОУ-ын баталгаажуулалтын SGS байгууллагаар магадлан аудитад орж Байгаль орчны удирдлагын тогтолцооны гэрчилгээг гардан авсан. Цаашид бид 2023 онд байгаль орчны удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах, хэрэгжилтийг хангах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллана.



Зураг.17 Тогтвортой хөгжлийн хэлтсийн бүтэц

“ГОВЬ” ХК-ИЙН “НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭР”-ИЙН  
БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



MONGOLIAN CASHMERE

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/465

Улаанбаатар хот

Бүтцийн өөрчлөлт хийх тухай


Хөдөлмөрийн дотоод журмын 2.5.3 дахь хэсгийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Компанийн 2022 оны бүтэц зохион байгуулалтыг Хавсралт №1-.....-д заасны дагуу баталж, 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Тэргүүн дэд захирал /Б.Ариунаа, Ц.Оргилболд/-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/262 тоот тушаал, Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны А/402 тоот тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.
3. Шинээр батлагдсан бүтэц, орон тооны дагуу үйл ажиллагаа, хүн хүчээ хэвийн зохион байгуулан тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд захирал /Б.Ариунаа, Ц.Оргилболд/-д, Хүний нөөцийн газар /Д.Соёлмаа/-г тус тус даалгасугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.БААТАРСАЙХАН



Зураг.18 Говь ХК-ийн бүтэц



#### 1.4. Төслийн тоног төхөөрөмж, техник болон дэд бүтэц

**Тоног төхөөрөмж:** “Говь” ХК-ийн тоног төхөөрөмжийн 65% нь Итали, Герман, Швейцар, Японых, 35% нь Хятад Тайваных байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийн хэлтэс албуудад техник, технологийн шинэчлэл байнга хийж үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлсээр ирсэн бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 1155 төрлийн тоног төхөөрөмж шинээр суурилуулсан. Нийт 1735 тоног төхөөрөмжтэй

#### **Цахилгаан эрчим хүч, дулааны хангамж:**

Төвийн эрчим хүч, дулаанд холбогдсон. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК болон “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-тай гэрээ байгуулсан.

#### **Усан хангамж:**

Төвлөрсөн шугамд холбогдсон. УСУГ-тай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” байгуулсан.

#### 1.5. Төслийн түүхий эд, туслах материал, эцсийн бүтээгдэхүүн

##### 1.5.1. Байгалийн гаралтай түүхий эд

##### **Төслийн үндсэн бүтээгдэхүүн/түүхий эд**

Үндсэн түүхий эд нь ямааны ноолуур, бөгөөд жилд 1000 тн ямааны ноолууранд гүн боловсруулалт хийж эцсийн ба завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэн 80%-ийг нь зах зээл өндөр хөгжсөн 30 гаруй орны 140-өөд харилцагчдадаа экспортлодогос гадаад дотоодын зах зээлд борлуулж байна.

Туслах түүхий эд, материал

Ноолуур, ноосонд гүн боловсруулалт хийх ноолууран болон ноосон сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 129 төрлийн химийн болон туслах материал хэрэглэдэг.

Эдгээр будаг, химийн бодис бусад туслах материалуудыг Япон, ОХУ, Хятад, Итали, Швейцарь, Англи, Герман зэрэг орноос авдаг ба зориулалтын агуулахад хадгалдаг.

Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх байгалийн гаралтай түүхий эд

Энэхүү төсөл нь үндсэн үйл ажиллагаандаа байгалийн баялгаас ус ашиглана. “Говь” ХК нь усаар хангагдах нөхцөлөөр II-р зэрэглэлийн объектод ордог бөгөөд үйлдвэр нь ус хангамжийг 3 зориулалтаар ашигладаг. Үүнд:

1. Үйлдвэрийн техникийн болон технологийн хэрэгцээнд
2. Ахуйн хэрэгцээнд

### 3. Усалгаа, гал унтраах зориулалтаар

Ус хэрэглээг төвлөрсөн шугамнаас хангадаг бөгөөд ус зөөлрүүлэгч 1 ба 2-р шатны шүүгчийг 2009 оны 4-р сард ашиглалтанд оруулсан. Зөөлрүүлэгч нь усны хатуулгийг 2 дахин бууруулснаар үйлдвэрийн усны хатуулаг 2.5 мг-экв/л хүрч ноос ноолуурын бүтээгдэхүүний чанарт нөлөөлж усны стандартын шаардлагыг бүрэн хангасан.

Мөн үйлдвэрийн барилга нь ус хангамжийн системд холбогдсон 3 цэгээс гал унтраах усыг авах боломжтой ба гал унтраах ПК-20 ширхэг, 2 насостой ба гал тэсвэрлэлтээрээ А зэрэглэлд багтдаг ба гал унтраах бүрэн ажиллагааны системтэй.

Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан хянаж, усыг ариг гамтай, үр ашигтай зарцуулах зорилгоор усны тоолуурыг тогтоосон хугацаанд стандарчлал, хэмжил зүйн газраар баталгаажуулдаг.

**Усны хэрэглээний тооцоо:** Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийг жилд тасралтгүй бүрэн хүчин чадлаар ажиллахад зарцуулах усны хэмжээг БОАЖЯ-ын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301-р тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцож хүснэгт 2-д харуулав. Үйлдвэрт нийт 2650 хүн ажиллах боловч нэг өдөрт 1700 хүн ажиллахаар тооцоо хийлээ.

### Үйлдвэрийн 2023 оны нийт ус хэрэглээний тооцоо

Хүснэгт 2

№	Ус ашиглалт	Хүчин чадал	Ус ашиглалт %	Ус хэрэглээний норм	Хоногийн ус хэрэглээ, м <sup>3</sup>	Жилийн нийт ус хэрэглээ, м <sup>3</sup>
1	АШҮ-Угаах		13%		195	14271
2	Ээрмэлийн үйлдвэр Будах, Холих	336.9 тн/жил	42%	136.1 /м <sup>3</sup> /	128	45615
2	Нэхмэл, Сүлжмэл, Оёмолын үйлдвэр	493120 ш/жил	21%	24.8 /1000 ш/	34	23051
3	Унд, ахуйн хэрэглээ	1500 хүн	15%	180 л	234	17566
4	Зүлэг, талбайн усалгаа 10%	8000 м <sup>2</sup>	1%	4 л	32	960
<b>Нийт</b>					<b>623</b>	<b>101463</b>

АШҮ-13%-Хоногт 195тн ус Будах ээрэх холих-42%, Нэхмэл Сүлжмэл Оёмол-21%, Бусад-16%

**Жич:** Зүлэг, зам талбайн усалгаа өдөр бүр хийгдэхгүй, жилд дунджаар хуурайшилттай үед 30 хоногт хийгдэнэ гэж тооцсон болно.

### 1.6. Төслөөс гарах хог хаягдал



Говь ХК нь ноос, ноолуурт гүн боловсруулалт хийдэг бөгөөд анхан шатны боловсруулалт хийгдэх үед амьтны гаралтай ноосны тос (зунгаг), хагаас гадна байгалийн гаралтай элс, тос, ургамлын үлдэгдэл, өтөг бууцны хог зэрэг хог хольцын 40-42% хүртэл бохирдолттой байдаг нь нотлогдсон зүйл юм. Эдгээр хольц хог нь ангилан ялгах (сэгсрэх), угаах, хялгас ялгах үед бүрэн цэвэрлэгддэг байна. Мөн ноос ноолуур пресслэх, хатаах, будах, холих, самнах, ээрэх, нэхэх, сүлжих, гүйцэтгэн боловсруулах үед амьтны, химийн гаралтай хатуу ба шингэн хог хаягдал гардаг.

### 1.6.1. Хатуу хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн, технологийн гаралтай хог хаягдал гарна. Энэхүү ахуйн хог хаягдлыг зохих журмын дагуу устгадаг байх бодлого баримтална.

**Ахуйн хатуу хог хаягдалд:** Цайны газрын хоолны үлдэгдэл, хүнсний зүйлийн үлдэгдэл, цаас, хуванцар, сав баглаа боодол, бусад хаягдлууд орно.

Засгийн газрын 2015 оны 288 дугаар тогтоолын хавсралт **ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ ТОГТООХ АРГАЧЛАЛ-ын дагуу** жилд гарах хатуу хогийг тооцно.

L- жилд гарах нийт хог хаягдал;

V- нэг өдөрт гарах хог хаягдлын норматив хэмжээ;

N- тооцох нэгжийн нийлбэр;

A- жилд ажиллах өдрийн тоо.

Иймд ахуйн гаралтай, дахин ашиглах боломжтой хатуу хог хаягдлыг ангилж ялгаж хогийн цэгт төвлөрүүлэн гэрээний дагуу зайлуулах чухал.


**Технологийн хатуу хог хаягдал** буюу цэвэрлэх байгууламжаас гарч байгаа лаг шавар багтана. Эдгээрийг хуулийн зохицуулалтын шаардлагын дагуу устгах. Дахин боловсруулах боломжуудыг судлах.

**Шингэн хаягдал**

“Говь” ХК нь жилд дунджаар 96 мянган м<sup>3</sup> бохир ус гарахаар тооцоо гарч байна. Бохир ус нь 48 худгаар дамжин төв бохирын станц дээр ирж шүүгдэн насосоор хотын төвлөрсөн бохирын шугам руу шахагдана.

### Цэвэршүүлэх байгууламж

“Говь” ХК нь бохир усны цэвэршүүлэх ТМ.F63В маркийн 2 шатны шүүгчийг 2009 оны 4-р сард ашиглалтад оруулсан. Мөн 2019 оны 03-р сарын 29-ны өдөр Үйлдвэрийн бохир усыг цэвэршүүлэх байгууламжыг “Ховдтул ХХК” гэрээ байгуулан шинэчилж эхэлсэн. Шинэчилсэн Цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.



Зураг.17 Цэвэрлэх байгууламжийн схем

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Хөрсөн бүрхэвч

- Хатуу хог хаягдал хадгалах цэг нь стандартын шаардлага хангаагүй байгаагаас хөрс бохирдох

### Агаарын чанар

- Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдах авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий.

### Усан орчин

- Усны нөөцийн хомсдол
- Усны бохирдол

### Хүний эрүүл мэнд

- Тоосжилт
- Дуу чимээ

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

**Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь:**

Үйл ажиллагаагаа явуулахдаа байгаль орчинд үүсэх болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана.

Үүнд:

- БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болсон байна.
- Ажиллагсад нэг бүр Говь ХК-ийн байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ, тэдэнд үүргээ биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэнтэй болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцсоноор хүрээлэн буй орчинд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвээр хадгалж, хамгаалах
- Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллана.
- Байгаль орчныг хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажилчдад таниулах ус, эрчим хүчээ хэмнэх зөв соёл хандлагыг хэвшүүлэх.

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хугацаа	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль стандарт
<b>Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>						
Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх автомашин, механизмын техникийн хэвийн ажиллагааг болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах	Тээвэрлэлт үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл	Жил бүр	-	116,000,0000	“ААХ”	MNS5013:2003, MNS5014:2003
Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах	Химийн бодис агуулах	Байнга	-	Дотоод төлөвлөлтөөр	Тогтвортой хөгжлийн хэлтэс, ҮТХ	MNS6458:2014
Агаарын мониторинг хийх	Үйлдвэрийн орчинд	2023	Жилд 2 удаа	ОХШХ-г багтсан	Итгэмжлэгдсэн лабораторитай “ТХХ” хамтран	MNS4585:2007
<b>Усны нөөц чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>						
Цэвэрлэх байгууламжийн ажиллах хэвийн үйл ажиллагааг хангах, бохир ус шүүх шүүлтүүр сеткийг цэвэрлэх	Үйлдвэр	2023	Тухай бүр	Дотоод төлөвлөлтөөр	ТУХ	MNS6390:2013
Хаягдал усны дүгнэлт гаргуулах	Үйлдвэр	2023	Тухай бүр	Дотоод төлөвлөлтөөр	ТУХ, ТХХ	
АШҮ-ын угаах 4 онгоноос 1 онгоцруу татсан шугам дээр тоолуур суурьлуулах	Үйлдвэр	2023	Тухай бүр	Дотоод төлөвлөлтөөр	ТУХ	
<b>Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>						
Үйлдвэрийн талбайн барилгажаагүй үлдсэн хэсэгт мод бут тарьж зүлэгжүүлэх	Төслийн талбай	2023	250 м <sup>2</sup> -аас дээш	Нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөөнд багтсан	“ТХХ”, “ААХ”	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

Хөрсний мониторинг	Төслийн талбай	2023	Жилд 2 удаа	ОХШХ-г багтсан	“ТХХ”	MNS5850:2008
--------------------	----------------	------	-------------	-------------------	-------	--------------

### 3.1. Нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөө

Үйлдвэрийн зам талбай нь зориулалтын хатуу хучилтгүй, ногоон байгууламж багатай байх нь тухайн орчинд ихээхэн тоосжилт үүсдэг. Тиймээс тус байгууллага нь энэ ажлыг жил бүр тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж талбайн шаардлагатай зам талбайн 80 гаруй хувийг хатуу хучилттай болгоно.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг үйлдвэрийн дотоод тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, мод бут,сөөг тарималжуулах, ургамалжуулах зэрэг ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай юм. “Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр”-ийн талбайн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нөхөн сэргээх болон ургамалжуулах ажлыг жил бүр хийнэ.

Газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм.

Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсан модлог ургамлыг арчлах, үхсэн хатсан хэсэгт нөхөн тарилт хийнэ.

#### Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

Хүснэгт 5


Хийгдэх ажил	Хамрах хүрээ	Тоо хэмжээ хэмжих нэгж	Хугацаа давтамж	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
Зүлэгжүүлэлт орчны тохижилт	Байгууллагын хашаан доторх ногоон байгууламжийн талбайг шинээр нэмэгдүүлэх	250 м <sup>2</sup> -аас дээш	2023	15,000,000	“ТХХ”, ААХ	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4
Том моддын хэлбэржүүлэлт	Гадаа талбай	45 ширхэг том мод	2023	3,060,000	“ТХХ, ААХ	
<b>Нийт дүн</b>				<b>18,060,000</b>		

#### Зүлэг тарих зөвлөмж

1. Талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5x2.5 сантиметрийн гишгүүрээр гишгиж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно.

2. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармуураар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучилт хийж зөөлөн шүршиж усалгаа хийнэ.

Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж усална. Зүлэгжүүлэх ажлыг тавдугаар сарын хоёрдугаар хагасаас долдугаар сарын 10-нд багтааж тарьна. Тарьсан үрээ соёлтол хөрсийг нь чийгтэй байлгахын тулд өдөр бүр өглөө оройн сэрүүнд нэг метр квадрат талбайд 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг метр квадрат талбайд 20-30 литр ус орохоор бодож долоо хоногт гурваас дөрвөн удаа услах бөгөөд гандуу үед өдөр бүр услах хэрэгтэй.



Зураг.18 Ерөнхий төлөвлөгөө, орчны тохижилт

### 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Бид дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр орчмын бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайд мод тарих ажил хийхээр төлөвлөсөн. Цаашид байгууллагын стратегийн төлөвлөгөөндөө энэхүү цэцэрлэгжүүлэлтийн ажлаар хийгдэх талбайг жил бүр нэмэгдүүлэн өөрсдийн үйл ажиллагаанаас Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, орчны тоосжилт, дуу чимээг багасгах, хөрсний үржил шимийг сайжруулан усны ундаргыг нэмэгдүүлэхэд олон талын ач холбогдолтой юм.

### 3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд тус дүүргийн засаг даргын 2017 оны 02 сарын 03-ны өдрийн А/55 тоот шийдвэрээр олгогдсон 178013/001 18639309696233 тоот нэгж талбарын дугаар бүхий үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмших 49883 м<sup>2</sup>, 178013/0060 18639309770292 тоот нэгж талбарын дугаар бүхий конторын зориулалтаар эзэмших 4467 м<sup>2</sup> талбайг 15 жилийн хугацаатай эзэмших эрхтэй байна.

Төслийг хэрэгжүүлэх 30 гаруй жилийн хугацаанд дүүрэг, хороо аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гарахгүй.

### 3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

### 3.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө



2009 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан **Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам**-ын дагуу. Химийн хорт болон аюултай бодисын захиалах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах MNS 6428:2014 Стандартын мөрдлөгө болгон ажиллана.

Агуулахын тоноглол: Агуулахын барилга нь 1 давхар, газардуулга, аянга зайлуулагчтай, шал нь тэгш, суурийг бетондсон, халаалтын системтэй, Бохир агаар гадагшлуулах агааржуулалтын системтэй жил бүр үзлэг хийж, засаж янзалдаг бөгөөд сууриас дээш бетондож, хаалганы хэсэгт налуу босго байгуулан шингэн химийн бодис гадагш алдагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, байгалийн аюулт үзэгдэл, гэнэтийн ослын үед ашиглах, душ, нүд угаагч суурилуулсан аваарын гарцны 1 том хаалгатай байна. .

Агуулахын цахилгааны монтажны утас нь хамгаалалтын бүрхүүлтэй, гэрэлтүүлэг хангалттай, аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээг харагдахуйц газарт байрлуулсан, галын дохиоллын систем гал унтраах тоноглолуудаар иж бүрэн хангагдсан.

Агуулахад хадгалж буй химийн бодисууд нь “Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль”-ийн 10-р зүйлийн 3 заалтын дагуу химийн материалын нэр, аюулын шинж чанар, анхааруулах тэмдгийг байрлуулсан байна.

### 3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хатуу хог хаягдал гарна.

Хог хаягдлыг хуванцар, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах нь зүйтэй. Ийнхүү хог хаягдлын төлөвлөгөөг гаргахдаа тус үйлдвэрийн бүхий л үйл ажиллагааны явцад гарч байгаа хог хаягдлын судалгааны үндсэн дээр боловсруулна.

#### Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Х.н	Тоо хэмжээ жилд тн	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
Ахуйн хуванцар сав /Ундаа, ус болон бусад/	Хогийн цэг	Тн/кг	1000	2,170,000	“ААХ”	“Эко орчин” ХХК тээвэрлэх шилжүүлэх	Хог хаягдлын тухай хууль, Хатуу хог
Хоолны газрын хатуу хог хаягдал		Тн/кг					

Бусад хатуу хог хаягдал /төмөр, мод, цаас гэх мэт/		Тн/кг					хаягдлыг журам
Хог хаягдлын менежмент	Байгууллагын хэмжээнд			7,500,000	“ТХХ”	“ААХ”	
Аюултай хог хаягдал	Эмнэлгийн хог хаягдал	кг	-	480,000	“ХЭМАБ-ын хэлтэс	“Элемент медикал” ХХК	БОАЖЯ сайдын 2018 оны А/18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Аюултай хог хаягдлын тухай хууль”
	Баттерей	Ш	3000	400,000	Тогтвортой хөгжлийн хэлтэс	“Түмэн эгшиг” ХХК	
	Химийн бодисын сав баглаа боодол	Ш	-	6,149,788	“ТХХ”, “ҮТХ”	“Цэцүүх трейд” ХХК	
<b>Нийт дүн</b>				<b>17,550,000</b>			

**3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

*Хүснэгт 6*

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран байгаль орчныг хамгаалах, зохистой хэрэглээ хэмнэлтийн сургалт зохион байгуулах, нийт ажилтануудад постер мэдээлэл түгээх	Жил бүр	10,495,000	ТХХ, ХЭМАБ	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, БО-ны гол асуудлуудаа хэмжиж, бохирдлыг бууруулах
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, Байгаль орчны гол асуудлуудаа хянах, мэдээллэх сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	Жил бүр	2,500,000		
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр		
4	ISO 14001:2015, Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын хэрэгжилтыг хангаж ажиллах	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр	“Говь” ХК	Байгууллагын нэр хүнд өсч, төр захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд болон хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамж дээшилнэ; Бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дэлхийн зах зээлд өрсөлдөж, олон улсын төсөл, тендерүүдэд оролцох боломжтой болно,

					Үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна.
6	Химийн бодисын сав баглаа боодлыг БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэх	2023 он	6,149,788	ТХХ, ҮТХ	Химийн бодисын хэрэглээнээс үүсэх Байгаль орчны сөрөг нөлөөлөл буурна.
7	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	2023 он 1-р улирал	44,000,000	Тогтвортой хөгжлийн хэлтэс	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
8	Газрын чанарын улсын хянан баталгаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх	2023 он 1-р улирал	24,000,000	Тогтвортой хөгжлийн хэлтэс	Газрын тухай хууль 58.5 Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа
9	Байгаль орчны хөндлөнгийн аудит	2023 он 1-р улирал	10,000,000	Тогтвортой хөгжлийн хэлтэс	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 10.1
<b>Дүн</b>			<b>97,144,788</b>		

### 3.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч

хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Ийнхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2011 оны 2-р сарын 16-ны өдрийн БОАЖЯ-ны сайдын №А-36 тоот тушаал “Журам шинэчлэн батлах тухай /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам/-ыг удирдлага болгон ашиглав.

Орчны хяналт шинжилгээний дүнгүүдийг өмнөх дүнгүүдтэй харьцуулж өөрчлөлтийг хянах бөгөөд байж болох дээд хязгаар нь стандарт байна.

### НЭГ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

#### 1.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

- ❖ Төслийн талбайн хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл

#### 1.2. Хяналт - шинжилгээ явуулах үзүүлэлт:

- ❖ Cd, Cr, Hg, Br, Pb, Zn, Cu, Co, Sr, Rb, Zr зэрэг хүнд металлын бохирдлын төвшнийг тодорхойлуулах

#### 1.3. Байршил

- ✓ Хог хаягдлын цэг болон химийн бодисын агуулах орчимын цэг

#### 1.4. Хийх ажлын дараалал

- ❖ Хөрсний зүсэлт хийх (0.5-1.0 м гүн).
- ❖ Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна.
- ❖ Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ
- ❖ Дээж авалт (дээж тус бүр гүн, өнгө, ... солбицол бичсэн хаягтай байна)
- ❖ Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

#### 1.5. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график

- ❖ Жилд 2 удаа

#### 1.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- ❖ Зүсэлт хийх хүрз
- ❖ Хөрс дээжлэгч уут, сав
- ❖ Фото аппарат

#### 1.7. Аргачлал

- ❖ MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- ❖ MNS 3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
- ❖ MNS 3298-1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд

- ❖ MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

1.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- ❖ Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008.

ХОЁР. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

2.1. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

- ❖ Хэрэглээгээс гарсан цэвэршүүлсэн бохир ус

2.2. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт

- ❖ MNS6561:2015 –д заасан үзүүлэлтүүд

2.3. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- ❖ Сорьц авч шинжилгээ хийлгэх

2.4. Байршил

- ❖ Цэвэрлэх байгууламж

2.5. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- ❖ Дээжлэгч болон цэвэрхэн усны шил, сав

2.6. Хийх ажлын дараалал

- ❖ Усны дээж авах саваа бэлтгэнэ, сайтар цэвэрлэсэн байна.
- ❖ Дээж авах гэж буй усаар сав болон бөглөөг 2-3 удаа зайлна.
- ❖ Дээж авалт (дээж тус бүр хаягтай байна).
- ❖ Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

2.7. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа график

- ❖ Жилд 2 удаа

2.9. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- ❖ “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага” MNS 6390:2013

ГУРАВ. АГААР ОРЧНЫ БОХИРДОЛ

3.1. Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд:

- ❖ Агаар дахь NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>-ийн агууламж, тоос PM10, PM2.5, дуу чимээ

3.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:

- ❖ Сорьц авах (агаар, тоос,)
- ❖ Хэмжилт хийх (NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>, тоосжилт, дуу шуугиан)

3.3. Байршил

- ❖ Үйлдвэрийн дотоод орчин

#### 3.4. Хийх ажлын дараалал:

- ❖ Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулна.
- ❖ Орчны бичиглэл хийнэ. Цаг агаарын төлөв байдлын талаар орчны бичиглэл хийнэ.
- ❖ Хэмжилт хийх үеийн агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлнө.
- ❖ Зориулалтын автомат багажны тусламжтайгаар хэмжилтийг гүйцэтгэнэ.

#### 3.5. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж:

- ❖ Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээг улиралд 2 удаа

#### 3.6. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:

- ❖ MNS 5003:2000. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих
- ❖ MNS 0017-5.1.21:92. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ, дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга
- ❖ MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс
- ❖ Бусад хамаарах аргачлал

#### 3.7. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:

- MNS 0012-013:91. Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага
- Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4585 :2007
- Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885 : 2008
- MNS 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
- MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

#### ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

“Говь” ХК-ийн Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдэр” төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус байгууллага нь бүрэн хариуцна.

Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЗЛ, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Монгол ус ТӨҮГ-ын усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.



Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль стандарт
<b>Хөрс</b>									
Хүнд элементийн шинжилгээ /12 элемент/	Хогийн цэг, химийн бодисын агуулах орчмоос	ш	2 удаа	114,000	228,000	Тогтвортой хөгжлийн хэлтэс	“Байгаль орчны хэмжилзүйн лаборатори”	Шинжилгээний дүн	MNS 5850:2008
<b>Дүн</b>				<b>114,000</b>	<b>228,000</b>				
<b>Агаар</b>									
NO <sub>2</sub> , SO <sub>2</sub>	Үйлдвэрийн гаднах талбайд	ш	2 удаа	320,000	640,000	Тогтвортой хөгжлийн хэлтэс	“Байгаль орчны хэмжилзүйн лаборатори”	Шинжилгээний дүн	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4585 :2007
Тоос PM10, PM2.5									
Дуу чимээ									
<b>Дүн</b>				<b>320,000</b>	<b>640,000</b>				
<b>Ус</b>									
Бохир усны	Цэвэрлэх байгууламж	ш	4 удаа	65,000	260,000	ТУХ	“Байгаль орчны хэмжилзүйн лаборатори”, УСҮГ, Усны төв лаборатори,	Шинжилгээний дүн	MNS6561:2015
Цэвэр усны	Цэвэр усаар хангагдаж байгаа шугамаас	ш	5 цэгээс 4 удаа	50,000	200,000	“ХЭМАБ”, “ААХ”	“Байгаль орчны хэмжилзүйн лаборатори”	Шинжилгээний дүн	MNS0900:2018
<b>Дүн</b>				<b>115,000</b>	<b>460,000</b>				
<b>Нийт дүн</b>	<b>1,328,000</b>								



**4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Хүснэгт 8

Сар өдөр	Хаана	Тайлбар
2023-12-01	Нийслэлийн БО-ны газар	Урьд оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлэх
2023-12-15	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Ирэх оны төлөвлөгөөг батлуулах

**5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ**

Хүснэгт 9

№	Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал	116,000,000
2	Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал	18,060,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7,000,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	17,550,000
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал	97,144,788
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарах зардал	1,328,000
<b>Нийт</b>		<b>257,082,788</b>

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, нөхөн сэргээлт, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.